



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

Огноо: 2010/04/16

Дугаар: 133

Улаанбаатар хот

Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж батлах тухай

Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх 2010-2011 оны үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Удирдамжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсөв болон олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (С.Энхболд)-т даалгасугай.

САЙД

С.ЛАМБАА

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 133 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг 2010-2011 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж

Нэг. ЗОРИЛГО: Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авч, тархалтыг хязгаарлана.

ЗОРИЛТ 1

1. Шинэ болон сэргэж буй халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авах.

Хүлээгдэж буй үр дүн :

1. Халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ, тандалтын талаар гарсан тушаал, заавар шинэчлэгдэнэ.
2. Халдварт өвчний голомтод эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авна.
3. Хариу арга хэмжээ авах багуудыг байгуулж, чадавхжуулна.
4. Сонгодсон аймгууд лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамрагдана.
5. Лабораторийн гадаад, дотоод чанарын хяналт, баталгаажилт сайжирна.

ЗОРИЛТ 2

Эрсдлийн үеийн мэдээлэл, харилцаа, холбоог сайжруулах.

Хүлээгдэж буй үр дүн :

1. Эрсдлийн үеийн харилцаа холбооны баг байгуулагдаж, салбар хоорондын харилцаа холбоо, мэдээлэл дамжуулалт сайжирна.
2. Эрсдлийн үед хүн амыг үнэн зөв мэдээллээр хангана.

ЗОРИЛТ 3

Олон улсын болон салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг сайжруулах.

Хүлээгдэж буй үр дүн :

1. Салбар хоорондын хамтын ажиллагаа өргөжинө.
2. Зоонозын халдварын хариу арга хэмжээний чадавхийг түвшин бүрт үнэлнэ.

Хоёр. Удирдамжийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

ХӨСҮТ-ийн тандалтын үндэсний нэгж шалгуур үзүүлэлтийн дагуу удирдамжийн хэрэгжилтийг хянана.

Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2009 он/	2011 оны зорилт
Халдварт өвчний дэгдэлтийн үед ажиллах	15	30

шуурхай хариу арга хэмжээний багийн тоо		
Халдварт өвчний дэгдэлтийн голомтод 24-48 цагийн дотор хариу арга хэмжээ авсан хувь	60%	90%
Лабораториор баталгаажсан халдварт өвчний хамшинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлуудын хувь	40%	70%
Эрсдлийн үеийн харилцаа холбооны талаар сургагдсан мэргэжилтний тоо	50	200

Гурав. Удирдамжийн хэрэгжилтийн зохион байгуулалт

Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийн үйл ажиллагааны удирдамжийг 2010-2011 онд хэрэгжүүлнэ. Үйл ажиллагааны удирдамжийг хэрэгжилтийг зохион байгуулах оролцогч байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар гүйцэтгэнэ.

Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, бусад төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

Дөрөв. Санхүүжилт

Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийн үйл ажиллагааны удирдамжийг 2010-2011 онд хэрэгжүүлэхэд 211 000 000 төгрөг шаардагдаж байна. Засгийн газар, ДЭМБ, Дэлхийн банк, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр уг стратегийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 4 дүгээр сарын 16-ны
өдрийн 133 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратегийн 2010-2011 оны
үйл ажиллагааны төлөвлөгөө

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /он/	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Төсөв /төгрөгөөр/	Эх үүсвэр
Нэг. Шинэ болон сэргэж буй халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авах							
1.1.	“Халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тандалтын тогтолцоог бэхжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын тушаалыг шинэчлэх.	2010	Тушаал	ЭМЯ	ХӨСҮТ		
1.2.	Халдварт өвчний дэгдэлтийн хариу арга хэмжээ авах багуудыг аймгийн түвшинд байгуулах.	2010-2011	Баг байгуулсан шийдвэр	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ		
1.3.	Халдварт өвчний дэгдэлтийн хариу арга хэмжээ авах багийн ажиллах журмыг боловсруулах.	2010	Журам	ХӨСҮТ	БГХӨСҮТ		
1.4.	Халдварт өвчний дэгдэлтийн хариу арга хэмжээ авах багт сургалт зохион байгуулах.	2010-2011	Сургалтын тайлан	ХӨСҮТ	БГХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	20 000 000	ДЭМБ
1.5.	Халдварт өвчний дэгдэлтийн хариу арга хэмжээний багийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.	2010-2011	Тоног төхөөрөмжийн тоо, төрөл	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	40 000 000	ДЭМБ, Дэлхийн банк
1.6.	Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчлөлийн газар	2010-2011	Тайлан	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн	6 000 000	Дэлхийн банк

	зүйн мэдээллийн GIS програмыг суурилуулах.				ЭМГ		
1.7.	Тандалтын хяналт, үнэлгээний гарын авлага боловсруулах, хэвлүүлэх.	2010	Гарын авлага	ХӨСҮТ	БГХӨСҮТ	5 000 000	ДЭМБ
1.8.	ЭСХАХА тандалтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх.	2010	Үнэлгээний тайлан	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	5 000 000	ДЭМБ
1.9	Сонгосон аймгуудыг лабораторийн чанарын сүлжээнд хамруулах.	2010-2011	Тайлан	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	20 000 000	ДЭМБ
1.10	Лабораторийн чанарын хяналтын талаар сургалт зохион байгуулах.	2010-2011	Тайлан	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	10 000 000	Дэлхийн банк
1.11	Лабораторийн урвалж, оношлуур, тоног төхөөрөмжөөр хангах.	2010-2011	Тоног төхөөрөмжийн тоо, төрөл	ЭМЯ	ХӨСҮТ	40 000 000	Дэлхийн банк
1.12	Лабораторийн өсгөвөрийг лавлагаа лабораторит баталгаажуулах.	2010-2011	Тайлан	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	5 000 000	ДЭМБ
1.13.	Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үндэсний стратеги /2011-2015 он/ боловсруулах	2010-2011	Стратеги	ЭМЯ	ХӨСҮТ		
Хоёр. Эрсдлийн үеийн мэдээлэл, харилцаа, холбоог сайжруулах.							
2.1.	Эрсдлийн үеийн харилцаа холбооны баг байгуулах.	2010	Тайлан	ЭМЯ	ХӨСҮТ, БГХӨСҮТ, ОБЕГ, МЭХ		
2.2.	Эрсдлийн үеийн харилцаа холбооны багийн ажиллах журмыг боловсруулах.	2010	Журам	ЭМЯ	ХӨСҮТ		
2.3.	Эрсдлийн үеийн харилцаа, холбооны талаар сургалт зохион байгуулах.	2010-2011	Тайлан	ХӨСҮТ	БГХӨСҮТ, ОБЕГ, МЭХ	5 000 000	Дэлхийн банк

2.4	Эрсдлийн үеийн харилцаа холбооны талаар хэвлэл мэдээллийн ажилтнуудад сургалт зохион байгуулах.	2010-2011	Тайлан	ХӨСҮТ	БГХӨСҮТ, ОБЕГ, МЭХ	10 000 000	Дэлхийн банк
Гурав. Олон улсын болон салбар хоорондын хамтын ажиллагааны уялдааг сайжруулах.							
3.1.	Зоонозын халдварын голомтын тандалт, судалгааг хөрш орнуудтай хамтран хийх.	2010-2011	Тайлан	БГХӨСҮТ	ХӨСҮТ, МЭХ	10 000 000	Засгийн газар
3.2.	Зоонозын халдварын хариу арга хэмжээний чадавхийг үнэлэх үнэлгээ хийх.	2010-2011	Тайлан	БГХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	15 000 000	ДЭМБ, Дэлхийн банк
3.3.	Зоонозын халдварын голомтод авах арга хэмжээний хамтарсан үзүүлэх сургууль зохион байгуулах.	2010-2011	Тайлан	БГХӨСҮТ	ОБЕГ, ХӨСҮТ, МЭХ	20 000 000	Дэлхийн банк
3.4.	Салбар хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.	2010-2011	Төлөвлөгөө	БГХӨСҮТ	ХӨСҮТ		
	Дүн					211 000 000	